

БАТЛАВ
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.АЮУРБУНЬ
2025 оны 05 дугаар сарын 15-ний өдөр

УДИРДАМЖ

Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, хөгжмийн зохиолч
Л.Дашнямын нэрэмжит дуу дуулаачдын улсын
уралдаан зохион байгуулах тухай

2025.03.31

Чингис хот

НЭГ.Үндэслэл

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 04 дүгээр тогтоол, Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын 2025 онд хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээг тус тус үндэслэв.

ХОЁР. Уралдааны зорилго

Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Л.Дашнямын нэрэмжит дуу дуулаачдын улсын уралдаан нь хөгжмийн зохиолчийн төрөлх нутгийг сурталчлах, түүний уран бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн үлдээх, өсөх ирээдүйтэй залуу дуучдыг тодруулан алдаршуулахад оршино.

ГУРАВ. Уралдааны зохион байгуулалт, хугацаа

- 3.1 Уралдааны I, II шатны шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий Чуулгын байранд зохион байгуулагдана.
- 3.2 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 18⁰⁰ цагт техникийн зөвлөгөөн хийж, оролцогчдын дарааллыг сугалуулна.
- 3.3 Нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 10⁰⁰ цагт Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгад болно.
- 3.4 Уралдааныг А. Мэргэжлийн, Б. Сонирхогчдын гэсэн 2 хэсэгт хувааж тус тус шалгаруулан байр эзлүүлнэ.
- 3.5 Тэмцээний “А” ангилалд оролцож буй уран бүтээлчдийг мэргэжлийн дуучин болохыг тодорхойлсон мэргэжлийн дипломын хуулбар эсхүл урлагийн байгууллагад ажиллаж буй албан тодорхойлолтыг үндэслэн оролцуулна.
- 3.6 Тэмцээний “Б” ангилалд мэргэжлийн бус буюу ардын авьяастнууд оролцоно.

- 3.7 Уралдаанд оролцох мэдүүлгийг 2025 оны 04-р сарын 10-ны өдрөөс 2025 оны 05-р сарын 05-ны өдрийн хооронд **Khan Khentii Ensemble /Хан Хэнтий чуулга/** /Хан Хэнтий чуулга/-ын пэйж хаягаар ирүүлнэ.
- 3.8 Оролцогч сонгосон дуугаа дараагийн шатанд давтан дуулахгүй.
- 3.9 Оролцогч мэргэжлийн өндөр төвшинд уран бүтээлээ бэлтгэсэн байна.
- 3.10 Уралдааны хураамж оролцогч тус бүр 50,000 төгрөг байна.
- 3.11 Уралдаанд оролцогчид нь хөгжим фонограмм болон хамтрах хөгжимчдийн байр, хоол, унааны зардлыг оролцогч тал буюу үндсэн байгууллага, хувь хүн өөрсдөө хариуцна.

ДӨРӨВ. Хамрах хүрээ

- 4.1 Монгол Улсын мэргэжлийн театр чуулгуудын мэргэжлийн дуулаачид оролцоно.
- 4.2 Насны ангилал 40 буюу 40 наснаас доош насны уран бүтээлчид оролцоно.

ТАВ. Шалгаруулах журам

- 5.1 Тус уралдаан 2 үе шаттайгаар зохион байгуулагдана.
- 5.2 А хэсэгт оролцогч тус бүр УГЗ Л.Дашнямын урын сангаас 2 дуу, монгол ардын 2 дуу нийт 4 дуу дуулна.
- 5.3 Б хэсэгт оролцогч тус бүр УГЗ Л.Дашнямын урын сангаас 2 дуу, монгол ардын 2 дуу нийт 4 дуу дуулна.
- 5.4 Уралдааны I шат **“А” хэсэгт оролцогч**
- Л.Дашнямын нэрэмжит дуу дуулаачдын улсын уралдаанд наадмын удирдамжийн хавсралтад заагдсан дуунуудаас 1 дууг сонгон дуулна.
 - Монгол ардын дуу 1-ийг тус тус дуулна.

“Б” хэсэгт оролцогч

- Л.Дашнямын урын сангаас хавсралтад заагдсан дуунуудаас 1 дууг сонгон дуулна.
- Монгол ардын богино дуу мөн 1-ийг дуулна.

5.5 Уралдааны II шат “А” хэсэгт оролцогч

- Л.Дашнямын урын сангаас хавсралтад заагдсан дуунуудаас 1 дууг сонгон дуулна.
- Монгол ардын дуу – 1-ийг тус тус дуулна.

“Б” хэсэгт оролцогч

- Л.Дашнямын урын сангаас хавсралтад заагдсан дуунуудаас 1 дууг сонгон дуулна.

- Монгол ардын богино 1 дуу.

5.6 Уралдаанд I – II дугаар шатанд сонгон дуулах дууг нэрсийн дагуу хавсралтад хавсаргав.

ЗУРГАА. Дүгнэх журам

- 6.1. Уран бүтээлчид үндэсний хөгжимтэй дуулна.
- 6.2 Уралдааныг мэргэжлийн шүүгчид шүүнэ.
- 6.3 Шүүгчдийн шийдвэр эцсийнх болно.
- 6.4 Шүүгчид дуулаачийн дуулах ур чадвар, дууны сонголт, дуугаа утгажуулан амьдруулж үзэгчдэд хэрхэн хүргэж байгаа болон I – II дугаар шатны нийлбэр дүнгээр дүгнэнэ.
- 6.5 Уралдааны шалгаруулалт нийтэд нээлттэй байна.

ДОЛОО. Шагналын сан

- 7.1 “А” хэсэг: УГЗ Л.Дашнямын нэрэмжит шагнал – 1,000,000₮
Тэргүүн байр өргөмжлөл – 3,000,000₮
Дэд байр өргөмжлөл – 2,000,000₮
Гутгаар байр өргөмжлөл – 1,000,000₮
Тусгай байр – 800,000₮
- 7.2 “Б” хэсэг: УГЗ Л.Дашнямын нэрэмжит шагнал – 1,000,000₮
Тэргүүн байр өргөмжлөл – 2,000,000₮
Дэд байр өргөмжлөл – 1,500,000₮
Гутгаар байр өргөмжлөл – 1,000,000₮
Тусгай байр – 500,000₮

Шилдэг хөгжмийн хамтлаг – 1,000,000₮

НАЙМ. Бүртгэл, бүрдүүлэх материал

- 8.1 Уралдааны удирдамж болзлыг Ардын дуу бүжгийн Хан Хэнтий Чуулгын Facebook Khanhentiichuulga цахим хуудаснаас татаж авна уу.
- 8.2 А, Б хэсэгт оролцогч I, II шатанд дуулах дууны нэрсийг бүтэн зөв бичсэн байх.
- 8.3 Уралдаанд оролцогчдын мэдүүлгийг Khan Khentii Ensemble /Хан Хэнтий чуулга/ пэйж хаягаар авах ба Хан Хэнтий Чуулгын байранд биечлэн ирж бүртгүүлэх боломжтой. Бүртгэл 2025 оны 04-р сарын 10-ны өдрөөс 2025 оны 05-р сарын 05-ыг дуустал хугацаанд явагдана.
- 8.4 Уралдааны талаар болон удирдамж болзолтой холбоотой мэдээллийг лавлах утас: 88012079, 91116109, Хөгжим лавлах утас: 89060631

ЕС.Зохион байгуулагч: Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
Хамтран зохион байгуулагч: Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Ардын дуу бүжгийн Хан Хэнтий Чуулга

Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн
хөгжмийн зохиолч Л.Дашнямын нэрэмжит дуу дуулаачдын
улсын уралдаант наадмын удирдамжийн хавсралт

Дууны нэрс

1. Үг: Ц.Гайтав "Нам тандаа баярлалаа"
2. Үг: Ц.Сүхбаатар "Өлгий нутгийн уянга"
3. Үг: Б.Түвшинжаргал "Октябрийн туяа"
4. Л.Дагвадорж "Эсэн мэндийн цэлгэр нутаг"
5. Үг: Ц.Нэргүй "Сайхан Монгол нутаг"
6. Үг: Моонон "Өссөн нутаг"
7. Үг: Г.Пүрэвдагва "Хэрлэн минь"
8. Үг: Д.Содномдорж "Ээжийн дуу"
9. Үг: Ш.Агваан-Осор "Буурлын сургаал"
10. Үг: Л.Агваанжамбал "малчин танаа"
11. Үг: Ж.Доржгочоо "Таван эрдэнэ"
12. Үг: Л.Дагвадорж, Ц.Жагдаг "Адуучин болох хүсэл байна"
13. Үг: Ц.Сүхбаатар "Хүний хүүгийн жаргал"
14. Үг: Ц.Нэргүй "Хөдөөг зорьё"
15. Үг: И.Агваандаш "Бэлчээрт дуулах дуу"
16. Үг: И.Агваандаш "Шөнийн бэлчээрт"
17. Үг: Л.Агваанжамбал "Жонон хонгор"
18. Үг: Л.Агваанжамбал "Хилэн хар"
19. Үг: Л.Агваанжамбал "Домогт алаг"
20. Үг: Л.Агваанжамбал "Үйзэн зээрд"
21. Үг: Ц.Сүхбаатар "Найгал хонгор"
22. Үг: С.Батаа "Уургын зээрд"
23. Үг: Ц.Сүхбаатар "Чандган талын тариалан"
24. Үг: Б.Түвшинжаргал "Сэтгэлийн уянга"
25. Үг: Л.Агваанжамбал "Чин хүслийн дуу"
26. Үг: Л.Агваанжамбал "Цэцгийн дунд"
27. Үг: Ц.Нэргүй "Болзоот хоёрын дуу"
28. Үг: Н.Ням-Осор "Анхилхан сарнай"

БАТЛАВ
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.АЮУРБУНЬ
2025 оны ... дугаар сарын ... ний өдөр

УДИРДАМЖ

Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, хөгжмийн зохиолч
Л.Дашнямын нэрэмжит цөөхүүл дууны хүүхдийн улсын
уралдаан зохион байгуулах тухай

2025.03.31

Чингис хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 04 дүгээр тогтоол, Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын 2025 онд хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээг тус тус үндэслэв.

ХОЁР. УРАЛДААНЫ ЗОРИЛГО:

Ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн багш нарын мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх, сурагчдын дуулах ур зүй, хөгжмийн авьяасыг хөгжүүлэх, түүнчлэн гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, урлагийн боловсролыг дэмжихэд оршино.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа төр болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн (4-8 хүүхдийн бүрэлдэхүүнтэй) сурагчид оролцоно.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР, ХУГАЦАА:

Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Л.Дашнямын нэрэмжит дууны хүүхдийн улсын уралдаант наадам 2025 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын байранд зохион байгуулагдана.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ерөнхий зохион байгуулагч: Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар,
Хамтран зохион байгуулагч: Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 18.00 цагт Хан Хэнтий чуулгын бага танхимд техникийн зөвлөгөөнийг хийж, оролцогчдын дарааллыг гаргах сугалаа сугалуулна.
- Орон нутгаас уралдаант наадамд оролцож байгаа хамтлагууд Хэнтий аймгийн Чингис хотод ирэх, буцах тээврийн болон наадамд оролцох өдрүүдийн байр, хоол, ундны зардлыг оролцогч тал хариуцна;
- Уралдаанд оролцогчид Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, биеийн тамир, спортын улсын хороо, Соёл урлагийн газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/277, А76, А604 тушаалаар батлагдсан “Соёл спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг дагаж мөрдөж, аюулгүй байдлыг хангах
- Уралдаант наадамд оролцох хамтлагууд, өөрсдийн сонгосон бүтээлийн нотыг шүүгчдийн бүрэлдэхүүнд хэвлэмэл байдлаар ирүүлнэ;

ДОЛОО. УРАЛДААНТ НААДАМД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Наадам 2 шаттай зохион байгуулагдах ба оролцох хамтлагууд 2 бүтээлээр оролцоно. Дуу нь хөгжимгүй болон төгөлдөр хуур эсвэл фонограммтай байж болно. Уралдаанд оролцогчдыг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

1. Урын сангийн сонголт болон дуулах бүрэлдэхүүн хоорондын холбоо хамаарлыг хангасан байдал
2. Дууны дуугаралт (хөг, үг хэллэг, хүчдэл, нийлэмж)
3. Удирдаач багшийн ур чадвар, дуулах арга техникийг эзэмшүүлсэн байдал
4. Бэлтгэл зохион байгуулалт (тайзны соёл, хувцаслалт)
5. Оролцогчдын тоо 4-8 хүүхэдтэй байна.
6. Улсын уралдааныг мэргэжлийн багш, уран бүтээлчид шүүнэ.

НАЙМ. УРАЛДААНЫ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

Тэргүүн байр- 1 Өргөмжлөл 1.500.000 төгрөг
Дэд байр-1 Өргөмжлөл 1.000.000 төгрөг
Гутгаар байр- 1 Өргөмжлөл 800.000 төгрөг
Тусгай байр- 2 Өргөмжлөл 500.000
Шилдэг багш-1 Өргөмжлөл 500.000 төгрөг
Нэрэмжит шагнал-1 Өргөмжлөл 400.000 төгрөг

ЕС. БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ:

Уралдаанд оролцогчдын мэдүүлгийг **Khan Khentii Ensemble /Хан Хэнтий чуулга/** пэйж хаягаар авах ба Хан Хэнтий Чуулгын байранд биечлэн ирж бүртгүүлэх боломжтой. Бүртгэл 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 05-ныг дуустал хугацаанд явагдана. Уралдааны талаар болон удирдамж болзолтой холбоотой асуудлыг лавлах утас:

Уралдааны талаар мэдээлэл авах утас: 88012079, 91116109
 Хөгжмийн чиглэлээр лавлах утас: 89060631

